



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 8/48

Арвайхээр

Гамшгийн үеийн нөхцөл байдалтай
холбогдуулан хөрөнгө зарцуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Хяналтын цэгийн шатахууны зардал 1,500,000 (нэг сая таван зуун мянга), "Арвайхээр нийтийн тээвэр, гэрэлтүүлэг," орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт ариутгал, халдваргүйтгэлийн зардал 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлыг сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийг зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Ж.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ГАНБАТ